

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ЗГ	Засгийн газар
ЗТХС	Зам тээврийн хөгжлийн сайд
МҮОНТ	Монголын үндэсний олон нийтийн телевизор
НББ	Нягтлан бодох бүртгэл
ШЕЗ	Шүүхийн ерөнхий зөвлөл
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	13
3.Аудитын тайлан.....	14
3.1. Ерөнхий зүйл.....	14
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	14
3.3. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт	15
3.4. Материаллаг байдал	15
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	15
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	17
3.7. Шилэн дансны мэдээлэл	18
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	18
3.9. Аудитын илрүүлэлт.....	18
Залруулсан алдаа.....	18
Аудитын зөвлөмж.....	18
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	19
4. Менежментийн захидал.....	20
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	22



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН
ГҮЙЦЭТГЭХ НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА О.АМГАЛАНБААТАР ТАНАА

2021.02.25 № 07/512
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын албаны 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын албаны 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Тус газрын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 46 зорилтын хүрээнд 91 арга хэмжээ төлөвлөснөөс гүйцэтгэлээр 95.6 хувийн биелэлтэй байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.


Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой. Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>262,629,037.88</u>	<u>335,566,325.96</u>
33	АВЛАГА	700,071.00	-
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	700,071.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	261,928,966.88	335,566,325.96
354	Хангамжийн материал	261,928,966.88	335,566,325.96
35410	Бичиг хэргийн материал	26,047,017.92	21,619,609.00
35420	Аж ахуйн материал	162,870,485.96	199,181,103.96
35430	Сэлбэг хэрэгсэл	31,489,200.00	42,494,200.00
35440	Түлш, шатах тослох материал	17,505,000.00	10,235,000.00
35470	Бусад хангамжийн материал	24,017,263.00	62,036,413.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>11,431,324,562.48</u>	<u>11,133,307,852.03</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	11,431,324,562.48	11,133,307,852.03
392	Биет хөрөнгө	9,460,134,742.52	9,153,793,865.46
38201	Барилга, байгууламж	9,061,510,507.50	9,061,510,507.50
39202	Хуримтлагдсан элэгдэл	(230,919,298.77)	(444,653,222.37)
39203	Авто тээврийн хэрэгсэл	1,178,647,200.00	1,178,647,200.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(1,134,508,788.74)	(1,156,869,422.16)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	1,675,156,498.38	1,690,534,612.38
39206	Хуримтлагдсан элэгдэл	(1,443,801,312.32)	(1,494,286,613.14)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	642,190,620.58	730,023,770.58
39208	Хуримтлагдсан элэгдэл	(384,551,169.16)	(483,077,753.96)
39214	Бусад үндсэн хөрөнгө	104,807,220.00	50,867,200.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(68,870,062.07)	(39,375,740.49)
39217	Номын фонд	60,473,327.12	60,473,327.12
393	Биет бус хөрөнгө	1,971,189,819.96	1,979,513,986.57
39301	Програм хангамж	295,005,390.00	346,005,390.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(211,300,390.04)	(253,976,223.43)
39303+393	Бусад биет бус хөрөнгө	1,887,484,820.00	1,887,484,820.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>11,693,953,600.36</u>	<u>11,468,874,177.99</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>11,693,953,600.36</u>	<u>11,468,874,177.99</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	11,693,953,600.36	11,468,874,177.99
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,646,495,144.95	2,646,495,144.95
51101	Өмч: - төрийн	759,010,324.95	759,010,324.95
51106	Эздийн өмчийн бусад хэсэг	1,887,484,820.00	1,887,484,820.00
512	Хуримтлагдсан үр дүн	6,403,154,468.74	6,178,075,046.37
51210	Өмнөх үеийн үр дүн	6,403,154,468.74	6,403,154,468.74
51220	Тайлант үеийн үр дүн	-	(225,079,422.37)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,644,303,986.67	2,644,303,986.67
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>11,693,953,600.36</u>	<u>11,468,874,177.99</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,193,668,531.00	3,397,894,427.98
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	93,979,931.00	281,907,699.98
120	Нийтлэг татварын бус орлого	93,979,931.00	281,907,699.98
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	92,315,511.00	281,907,699.98
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	75,858,934.00	272,183,700.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	16,456,577.00	9,723,999.98
120009	Бусад орлого	1,664,420.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,099,688,600.00	3,115,986,728.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,837,916,300.00	2,984,914,544.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,837,916,300.00	2,984,914,544.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	261,772,300.00	131,072,184.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	34,616,700.00	9,098,529.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	227,155,600.00	121,973,655.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,837,412,935.04	3,518,921,110.35
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,837,412,935.04	3,518,921,110.35
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,496,809,079.28	3,259,002,461.31
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,553,070,911.66	1,719,544,476.19
210101	Үндсэн цалин	1,103,684,875.66	1,238,723,576.19
210102	Нэмэгдэл	235,727,200.00	280,970,200.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	138,923,000.00	128,636,000.00
210104	Урамшуулал	74,735,836.00	71,214,700.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	196,291,123.24	219,945,530.22
210201	Тэтгэврийн даатгал	130,486,459.30	155,776,733.63
210202	Тэтгэмжийн даатгал	16,701,170.27	17,112,958.76
210203	ҮОМШӨ-ний даатгал	12,743,194.22	9,693,501.06
210204	Ажилгүйдлийн даатгал	3,317,238.63	4,447,955.77
210205	Эрүүл мэндийн даатгал	33,043,060.82	32,914,381.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	134,504,822.17	191,903,854.08
210301	Гэрэл, цахилгаан	47,732,142.07	48,689,163.47
210302	Түлш, халаалт	7,743,923.01	9,638,148.61
210303	Цэвэр, бохир ус	5,028,757.09	4,661,552.00
210304	Байрны түрээс	74,000,000.00	128,914,990.00
2104	Хангамж, бараа материалын зардал	225,267,349.22	263,430,492.39
210401	Бичиг хэрэг	52,140,669.20	42,290,285.92
210402	Тээвэр, шатахуун	74,730,000.00	51,357,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	20,808,293.62	73,273,485.47
210404	Ном, хэвлэл	11,520,000.00	35,075,060.00

Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын албаны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,200,000.00	1,181,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	64,868,386.40	60,253,161.00
2105	Нормативт зардал	325,000.00	962,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	325,000.00	962,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	112,621,796.00	23,689,670.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,254,400.00	2,520,300.00
210604	Урсгал засвар	111,367,396.00	21,169,370.00
2107	Томилолт, зочны зардал	39,264,400.00	24,898,100.00
210702	Дотоод албан томилолт	36,278,400.00	18,047,300.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	2,986,000.00	6,850,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	121,916,824.00	132,979,266.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	104,142,746.00	99,771,623.00
210803	Даатгалын үйлчилгээ	6,437,090.00	7,832,025.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	4,522,316.00	2,053,452.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	158,700.00	570,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,481,900.00	13,840,800.00
210807	Газрын төлбөр	5,174,072.00	8,911,366.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,113,546,852.99	681,649,072.43
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	136,603,316.00	123,940,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	180,218,029.60	113,205,478.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	796,725,507.39	444,503,594.43
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	340,603,855.76	259,918,649.04
2132	Бусад урсгал шилжүүлэг	222,256,617.00	117,866,277.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	9,147,133.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	147,474,618.00	36,074,144.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	74,781,999.00	72,645,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	118,347,238.76	142,052,372.04
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	118,347,238.76	142,052,372.04
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(643,744,404.04)	(121,026,682.37)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	622,386,900.44	104,052,740.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	622,386,900.44	104,052,740.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(622,386,900.44)	(104,052,740.00)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(1,266,131,304.48)	(225,079,422.37)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>3,177,211,954.00</u>	<u>3,391,632,999.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	77,244,934.00	275,646,271.00
120	Нийтлэг татварын бус орлого	77,244,934.00	275,646,271.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	75,858,934.00	275,646,271.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	75,858,934.00	275,646,271.00
120009	Бусад орлого	1,386,000.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,099,967,020.00	3,115,986,728.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,837,916,300.00	2,984,914,544.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,837,916,300.00	2,984,914,544.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	262,050,720.00	131,072,184.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	34,616,700.00	9,098,529.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	227,434,020.00	121,973,655.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>3,080,217,244.00</u>	<u>3,254,570,115.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,080,217,244.00	3,254,570,115.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,739,613,388.24	2,994,651,465.96
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,554,360,471.82	1,719,544,476.19
210101	Үндсэн цалин	1,104,974,435.82	1,238,723,576.19
210102	Нэмэгдэл	235,727,200.00	280,970,200.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	138,923,000.00	128,636,000.00
210104	Урамшуулал	74,735,836.00	71,214,700.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	198,227,065.63	219,945,530.22
210201	Тэтгэврийн даатгал	131,413,499.30	155,776,733.63
210202	Тэтгэмжийн даатгал	16,856,999.27	17,112,958.76
210203	ҮОМШӨ-ний даатгал	12,869,168.22	9,693,501.06
210204	Ажилгүйдлийн даатгал	3,371,199.02	4,447,955.77
210205	Эрүүл мэндийн даатгал	33,716,199.82	32,914,381.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	134,504,822.17	191,903,854.08
210301	Гэрэл, цахилгаан	47,732,142.07	48,689,163.47
210302	Түлш, халаалт	7,743,923.01	9,638,148.61
210303	Цэвэр, бохир ус	5,028,757.09	4,661,552.00
210304	Байрны түрээс	74,000,000.00	128,914,990.00
2104	Хангамж, бараа материалын зардал	214,641,038.62	273,658,247.47
210401	Бичиг хэрэг	47,964,980.00	41,068,620.00
210402	Тээвэр, шатахуун	68,998,000.00	43,753,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	20,998,293.62	73,273,485.47

Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын албаны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210404	Ном, хэвлэл	25,480,100.00	53,524,600.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,200,000.00	1,181,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	49,999,665.00	60,857,042.00
2105	Нормативт зардал	2,730,100.00	3,642,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,730,100.00	3,642,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	138,980,716.00	112,733,675.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	20,164,120.00	43,821,455.00
210602	Тавилга	8,000,000.00	40,365,150.00
210604	Урсгал засвар	110,816,596.00	28,547,070.00
2107	Томилолт, зочны зардал	54,777,400.00	30,809,800.00
210702	Дотоод албан томилолт	36,278,400.00	20,809,800.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	18,499,000.00	10,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	123,423,395.00	205,268,266.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	105,649,317.00	101,786,623.00
210803	Даатгалын үйлчилгээ	6,437,090.00	7,832,025.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	4,522,316.00	2,053,452.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	158,700.00	570,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,481,900.00	84,114,800.00
210807	Газрын төлбөр	5,174,072.00	8,911,366.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	317,968,379.00	237,145,617.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	136,566,268.00	123,940,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	181,402,111.00	113,205,617.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	340,603,855.76	259,918,649.04
2132	Бусад урсгал шилжүүлэг	222,256,617.00	117,866,277.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	9,147,133.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	147,474,618.00	36,074,144.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	74,781,999.00	72,645,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	118,347,238.76	142,052,372.04
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	118,347,238.76	142,052,372.04
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>96,994,710.00</u>	<u>137,062,884.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	96,994,710.00	137,062,884.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	96,994,710.00	137,062,884.00
2200	Дотоод эх үүсвэрээр	96,994,710.00	137,062,884.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	96,994,710.00	137,062,884.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(96,994,710.00)</u>	<u>(137,062,884.00)</u>

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,646,495,144.95	2,647,684,283.76	7,665,905,476.13	12,960,084,904.84
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	3,380,297.09	3,380,297.09
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,646,495,144.95	2,647,684,283.76	7,669,285,773.22	12,963,465,201.93
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	(3,380,297.09)	-	(3,380,297.09)
Тайлант үеийн үр дүн	-	-	(1,266,131,304.48)	(1,266,131,304.48)
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,646,495,144.95	2,644,303,986.67	6,403,154,468.74	11,693,953,600.36
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,646,495,144.95	2,644,303,986.67	6,403,154,468.74	11,693,953,600.36
Тайлант үеийн үр дүн	-	-	(225,079,422.37)	(225,079,422.37)
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,646,495,144.95	2,644,303,986.67	6,178,075,046.37	11,468,874,177.99

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/төгрөгөөр/	
			Зөрүү	Хувь
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-	-	
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,148,711,300.00	2,994,568,442.96	154,142,857.04	95.1
УРСГАЛ ЗАРДАЛ	3,148,711,300.00	2,994,568,442.96	154,142,857.04	95.1
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,078,897,300.00	2,926,702,165.96	152,195,134.04	95.1
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,732,641,800.00	1,711,456,896.19	21,184,903.81	98.8
Үндсэн цалин	1,229,962,700.00	1,230,635,996.19	(673,296.19)	100.1
Нэмэгдэл	280,970,700.00	37,343,115.00	243,627,585.00	13.3
Унаа хоолны хөнгөлөлт	137,116,100.00	24,012,000.00	113,104,100.00	17.5
Урамшуулал	84,592,300.00	6,059,817.00	78,532,483.00	7.2
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	238,003,900.00	218,934,581.22	19,069,318.78	92.0
Тэтгэврийн даатгал	171,648,300.00	154,765,784.63	16,882,515.37	90.2
Тэтгэмжийн даатгал	16,589,100.00	17,112,958.76	(523,858.76)	103.2
ҮОМШӨ-ний даатгал	5,134,100.00	9,693,501.06	(4,559,401.06)	188.8
Ажилгүйдлийн даатгал	11,454,500.00	4,447,955.77	7,006,544.23	38.8
Эрүүл мэндийн даатгал	33,177,900.00	32,914,381.00	263,519.00	99.2
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	195,966,300.00	191,903,854.08	4,062,445.92	97.9
Гэрэл, цахилгаан	51,248,300.00	48,689,163.47	2,559,136.53	95.0
Түлш, халаалт	10,514,000.00	9,638,148.61	875,851.39	91.7
Цэвэр, бохир ус	5,287,900.00	4,661,552.00	626,348.00	88.2
Байрны түрээс	128,916,100.00	128,914,990.00	1,110.00	100.0
Хангамж, бараа материалын зардал	291,252,200.00	273,658,247.47	17,593,952.53	94.0
Бичиг хэрэг	47,965,000.00	41,068,620.00	6,896,380.00	85.6
Тээвэр, шатахуун	43,762,200.00	43,753,000.00	9,200.00	100.0
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	80,400,000.00	73,273,485.47	7,126,514.53	91.1
Ном, хэвлэл	59,025,000.00	53,524,600.00	5,500,400.00	90.7
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,200,000.00	1,181,500.00	18,500.00	98.5
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	58,900,000.00	60,857,042.00	(1,957,042.00)	103.3
Нормативт зардал	4,000,000.00	3,642,000.00	358,000.00	91.1
Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,000,000.00	3,642,000.00	358,000.00	91.1
Эд хогшил, урсгал засварын зардал	33,333,400.00	9,608,289.00	23,725,111.00	28.8
Багаж, техник, хэрэгсэл	72,816,300.00	72,290,384.00	525,916.00	99.3
Тавилга	45,000,000.00	45,085,450.00	(85,450.00)	100.2
Урсгал засвар	50,000,000.00	28,547,070.00	21,452,930.00	57.1
Томилолт, зочны зардал	25,310,400.00	20,809,800.00	4,500,600.00	82.2

Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын албаны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Дотоод албан томилолт	25,310,400.00	20,809,800.00	4,500,600.00	82.2
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	309,526,600.00	247,168,266.00	62,358,334.00	79.9
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	138,392,800.00	92,686,623.00	45,706,177.00	67.0
Даатгалын үйлчилгээ	8,720,500.00	7,832,025.00	888,475.00	89.8
Тээврийн хэрэгслийн татвар	4,524,800.00	2,053,452.00	2,471,348.00	45.4
Тээврийн хэрэгслийн оношлогоо	600,000.00	570,000.00	30,000.00	95.0
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	148,363,500.00	135,114,800.00	13,248,700.00	91.1
Газрын төлбөр	8,925,000.00	8,911,366.00	13,634.00	99.8
Бараа үйлчилгээний бусад зардал	114,379,800.00	113,205,617.00	1,174,183.00	99.0
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	114,379,800.00	113,205,617.00	1,174,183.00	99.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	69,814,000.00	67,866,277.00	1,947,723.00	97.2
Бусад урсгал шилжүүлэг	69,814,000.00	67,866,277.00	1,947,723.00	97.2
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	9,200,000.00	9,147,133.00	52,867.00	99.4
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	37,614,000.00	36,074,144.00	1,539,856.00	95.9
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	23,000,000.00	22,645,000.00	355,000.00	98.5
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,148,711,300.00	2,994,568,442.96	154,142,857.04	95.1
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	3,028,711,300.00	2,846,324,742.96	182,386,557.04	94.0
Улсын төсвөөс санхүүжих	3,028,711,300.00	2,846,324,742.96	182,386,557.04	94.0
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	120,000,000.00	148,243,700.00	(28,243,700.00)	123.5
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	120,000,000.00	148,243,700.00	(28,243,700.00)	123.5
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00	-	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00	-	
БАЙГУУЛЛАГЫН ТОО	01	01	-	100.0
Төсвийн байгууллага	01	01	-	100.0
АЖИЛЛАГСДЫН ТОО	111	100	11	90.1
Удирдах ажилтан	20	12	8	60.0
Гүйцэтгэх ажилтан	72	69	3	95.8
Үйлчлэх ажилтан	18	18	-	100.0
Гэрээт ажилтан	01	01	-	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	131,072,184.00
УРСГАЛ ЗАРДАЛ	-	131,072,184.00
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	81,072,184.00
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	8,087,580.00
Үндсэн цалин	-	8,087,580.00
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	1,010,949.00
Тэтгэврийн даатгал	-	1,010,949.00
Эд хогшил, урсгал засварын зардал	-	52,873,655.00
Багаж, техник, хэрэгсэл	-	31,783,655.00
Тавилга	-	21,090,000.00
Томилолт, зочны зардал	-	10,000,000.00
Зочин төлөөлөгч хүлээн авах	-	10,000,000.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	9,100,000.00
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	9,100,000.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	50,000,000.00
Бусад урсгал шилжүүлэг	-	50,000,000.00
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	50,000,000.00
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	131,072,184.00
Нэмэлт санхүүжилтийн орлого	-	131,072,184.00
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	9,098,529.00
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	121,973,655.00
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	-	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын албаны 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Шүүхийн ерөнхий зөвлөлийн гүйцэтгэх нарийн бичгийн дарга О.Амгаланбаатар танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогыг бодитой тооцоо судалгаанд үндэслэн төлөвлөх, харьяа байгууллагуудтай тооцоо нийлсэн акт үйлдэх, үндсэн хөрөнгийн тооллого хийх, Хэрэгцээ шаардлагагүй бараа материалын нөөц үүсгэхгүй байх талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 25-аас 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Үндэсний аудитын газрын Хоёрдугаар газрын аудитын менежер С.Нацагдорж анхан шатны хяналтыг хэрэгжүүлж, аудитор Ц.Цэрэннамжил хариуцан гүйцэтгэв.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын албаны 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2021 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 03/65 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 4 дэх хэсэгт зааснаар Шүүхийн ерөнхий зөвлөл нь шүүх, шүүгчийн шүүн таслах ажиллагаанд оролцохгүйгээр, гагцхүү хуульчдаас шүүгчийг шилж олох, эрх ашгийг нь хамгаалах зэрэг шүүхийг бие даан ажиллах нөхцөлөөр хангах чиг үүрэгтэй. Энэ чиг үүргийн хүрээнд тус зөвлөлөөс иргэдийн шүүхэд мэдүүлэх эрхийг хангах, шүүхийн үйлчилгээний хүртээмжийг дээшлүүлэх зорилтыг 2020 онд дэвшүүлэн ажилласан байна. Үүнд:

- Дэлхий нийтэд короновирус ковид-19 цар тахал тархалтын үед шүүн таслах ажиллагааг хэвийн, тасралтгүй явуулахад чиглэсэн аргачлал, удирдамжийг баталж, анхан болон давж заалдах шатны шүүхийг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажилласан;
- Мэдээллийн технологи, хэргийн хөдөлгөөн, шүүхийн статистик, тайлан, мэдээний чиглэлээр нийт 245 шүүхийн захиргааны ажилтанд мэргэшүүлэх сургалтуудыг зохион байгуулж, 77 удаагийн танхимаар болон цахимаар сургалт зохион байгуулж, түүнд давхардсан тоогоор эрүү,иргэн, захиргаа, анхан болон давж заалдах шатны шүүхийн 1720 шүүгч, 518 шүүхийн захиргааны ажилтнуудыг хамруулсан;
- Шүүх, шүүхийн захиргааны ажлын онцлогийг нийгэмд таниулах, тулгамдаж буй асуудлыг хөндөх, эерэг мэдээлэл түгээхээр Монгол Улсын дээд шүүх болон МҮОНТ-тэй хамтран “Монгол Улсын нэрийн өмнөөс” нэвтрүүлгийг 24 удаа олон нийтэд хүргэж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Засгийн газрын 2019 оны 472 дугаар Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай тогтоолоор цалингийн сүлжээнд өөрчлөлт орж 2020 оны 01 дүгээр сараас дагаж мөрдсөн;

- ЗТХС-ын 2019 оны 390 дүгээр “Жишиг норм батлах тухай” тушаалыг үндэслэн ШЕЗ-ийн даргын 2020 оны 63 дугаар “Авто машины шатахууны зарцуулалтын норм тогтоох тухай” тогтоол баталж дагаж мөрдсөн.

3.3. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын алба санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн Хяналт-шалгалт, үнэлгээ, дотоод аудитын албанаас 2020 онд Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын албаны 2019 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийж, бараа материалын үлдэгдэлтэй байгаа тул нэмж худалдан авалт хийхгүй байх зөвлөмж өгсөн байна.

Өгсөн зөвлөмжийн дагуу тайлант онд бичиг хэргийн материал болон түлш, шатах тослох материалын зардлын төлөвлөөг тус бүр 20,000.0 мянган төгрөгөөр бууруулж батлуулсан.

Хяналт-шалгалт, үнэлгээ, дотоод аудитын албанаас 2020 оны 06 дугаар сарын байдлаарх шилэн дансанд аудит хийж, зөрчилгүй дүгнэлт өгсөн байна.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 3,744,947.5 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 74,898.9 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсон.

Гүйцэтгэлийн үе шатанд санхүүгийн үр дүнгийн тайланд залруулга орсон тул материаллаг байдлын түвшинг нийт зардал 3,622,973.9 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 72,459.5 мянган төгрөг болгон өөрчилсөн.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын албаны 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 225,079.4 мянган төгрөгөөр буюу 1.9 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

			/мянган төгрөг/
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-

Авлага	700.0	-	(700.0)
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	261,929.0	335,566.3	73,637.3
Үндсэн хөрөнгө	11,431,324.6	11,133,307.9	(298,016.7)
Нийт хөрөнгө	11,693,953.6	11,468,874.2	(225,079.4)
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	11,693,953.6	11,468,874.2	(225,079.4)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	11,693,953.6	11,468,874.2	(225,079.4)

Авлага дансны эхний үлдэгдэл 700.0 мянган төгрөгөөр цалингийн авлага бүрэн төлөгдсөн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 335,566.3 мянган төгрөг болж 73,637.3 мянган төгрөгөөр өссөн нь Шүүхийн тамгын газруудад шилжүүлэхээр бэлтгэсэн хөрөнгийг 2021 онд олгохоор төлөвлөж бусад хангамжийн материал дансанд бүртгэснээс шалтгаалжээ.

Оны эцэст 15,785.0 мянган төгрөгийн түлш, шатах, тослох материал болон сэлбэг хэрэгслийн материалын худалдан авалт хийж бараа материалын нөөц үүсгэсэнд аудитаар зөвлөмж өгсөн.

Бараа материалын дансанд 2020 онд худалдан авалтаар бэлтгэсэн 50,311.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг харьяа байгууллагууд Ковид-19 цар тахлын улмаас хөл хорио тогтоосноос шалтгаалан шилжүүлээгүй бүртгэлтэй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 11,468,874.2 мянган төгрөг болж 298,016.7 мянган төгрөгөөр буурсан нь ТӨБЗГ-ын 2020 оны А-1/1628, А-1/1551 дугаар албан бичгээр шүүхийн тамгын газруудад үнэ төлбөргүй шилжүүлсэн, ТӨБЗГ-ын 2020 оны А-1/947, А-1/2157 дугаар албан бичгээр хөрөнгийг акталсан, тайлант оны хуримтлагдсан элэгдлийн зардлаар хөрөнгийн үлдэх өртөг хасагдсанаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө үнэ төлбөргүй шилжүүлсэн 23,214.4 мянга, акталсан 23,818.0 мянган төгрөгийн хөрөнгөөр хасагдсан байна.

Биет бус хөрөнгө өссөн нь төсвийн хөрөнгөөр 51,000.0 мянган төгрөгийн программ хангамж худалдан авч мөн цахим санг хөгжүүлснээс шалгаасан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 11,468,874.2 мянган төгрөг болж 225,079.4 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны санхүүгийн үйл ажиллагааны үр дүнгээс шалтгаалжээ.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын албаны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 204,225.9 мянган төгрөгөөр буюу 6.4 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь улсын төсвийн санхүүжилт болон туслах үйл ажиллагааны орлого байна. Энэ нь урсгал зардлын төлөвлөгөөгөө нэмэгдүүлж батлуулсан болон иргэд, аж ахуйн нэгжийн Шүүхийн төрөлжсөн архиваас авах үйлчилгээ нэмэгдсэн байна.

Нийт зардал өмнөх оноос 836,826.0 мянган төгрөгөөр буюу 18.8 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол болон тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийн зардлууд байна. Энэ нь үндсэн хөрөнгө хуримтлагдсан элэгдлээр анхны өртгөө нөхсөн хөрөнгө болон тэтгэвэрт гарах ажилтны тоо цөөрсөнтэй холбоотой байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 3,312,234.2 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 3,312,234.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 163,522.9 мянган төгрөгөөр бууруулж 3,148,711.3 мянган төгрөгөөр баталсан байна. Төсвийн төсөлд материаллаг өөрчлөлт гарсан нь байр ашиглалттай холбоотой зардал болон цалингийн зардлыг бууруулж баталсан байна. Энэ нь ЗГ-ын XI байранд түрээсэлдэг байрны түрээсийн зардлыг ирүүлсэн саналын дагуу төсөвлөж оруулсан боловч өмнөх оны зардалтай ижил баталсан мөн илүү цагийн нэмэгдэл хөлсийг хүргүүлсэн саналаас бууруулж баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх Шүүхийн бие даасан хараат бус байдлыг хангах хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр 3,148,711.3 мянган төгрөгийн төсөв баталснаас 3,028,711.3 мянган төгрөгийг улсын төсвөөс, 120,000.0 мянган төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Төсвийн гүйцэтгэлээр улсын төсвөөс 2,984,914.5 мянган төгрөгийн санхүүжилт авч, туслах үйл ажиллагааны орлого 148,243.7 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, нийт 3,133,158.2 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 2,994,568.4 мянган төгрөгийг зарцуулж 142,052.4 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,994,568.4 мянган төгрөг буюу 95.1 хувьтай байгаа нь бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 62,358.3 мянган төгрөгөөр, эд хогшил худалдан авах зардлыг 21,893.4 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь Шүүхийн бие даасан хараат бус байдлыг хангах хөтөлбөрийн үндсэн үйл ажиллагаа /80101/ арга хэмжээ 108,198.4 мянган төгрөгөөр, мөн хөтөлбөрийн мэдээлэл сурталчилгаа /80205/ арга хэмжээ 40,140.0 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулагдсантай холбоотой байна. Хүснэгтээр харуулбал:

/мянган төгрөг/

Хөтөлбөр, арга хэмжээ		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Хөтөлбөр -Шүүхийн бие даасан хараат бус байдлыг хангах 70701		3,148,711.3	2,994,568.4	154,142.9	95.1
Арга хэмжээ	Үндсэн үйл ажиллагаа 80101	2,973,504.5	2,865,306.1	108,198.4	96.4
	Мэдээлэл, сурталчилгаа 80205	40,140.0	-	40,140.0	-
	Зөвлөл хороо комиссын гишүүдийн ажлын хөлс 80224	55,152.8	53,114.1	2,038.7	96.3
	Цахим хуудасны бүртгэлийн хураамж 80228	10,100.0	8,282.0	1,818.0	82.0
	Ажил олгогчоос олгох тэтгэмж, шагнал, урамшуулал 80802	60,614.0	58,719.1	1,894.9	96.9
	Бүтцийн өөрчлөлтөөр чөлөөлөгдсөн 80812	9,200.00	9,147.10	52.9	99.4

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Хандив тусламжаар 9,098.5 мянга, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 121,973.7 мянга, нийт 131,072.2 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс цалин хөлс болон нэмэгдэл урамшилд 8,087.6 мянга, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлд 1,010.9 мянга, эд хогшил, урсгал засварын зардалд 52,873.6 мянга, томилолт, зочны зардалд 10,000.0 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжид 9,100.0 мянга, ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулалд 50,000.0 мянга, нийт 131,072.2 мянган төгрөгийг зарцуулжээ.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан *"Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"*-ыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 107 мэдээллээс хугацаандаа оруулсан 96, хугацаа болоогүй 1, хугацаа хоцроосон 10 мэдээлэл байгаа бөгөөд шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй мэдээлэл байхгүй байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын түүвэрт хамрагдаж өгсөн 1 зөвлөмжийн хэрэгжилт 100.0 хувьтай байна.

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 141,221.3 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 125,436.3 мянган төгрөгийн алдааг залруулж, 15,785.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Төсвийн гүйцэтгэлийн тайланг 3,462.6 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан нь Сангийн сайдын 2012 оны 76 дугаар тушаалаар баталсан Төсвийн гүйцэтгэлийн тайлан боловсруулах журмын 2-т заасан *"Төсвийн гүйцэтгэлийн тайлан боловсруулах зарчим"*-тай нийцээгүй тул аудитын явцад залруулсан;
2. Санхүүгийн үр дүнгийн болон Мөнгөн гүйлгээний тайланг 121,973.7 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан нь НББ-ийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д *"Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккрузл сууриар хөтөлнө"* гэж заасантай нийцэхгүй тул аудитын явцад залруулсан.

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 15,785.0 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 4 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын алба нь харьяа шүүхийн тамгын газруудад хуваарилах хөрөнгийг бараа материалын дансандаа төвлөрүүлээд тараадаг бөгөөд харьяа газруудтай тооцоо нийлсэн актыг дутуу үйлддэг нь ТЕЗ-ийн санхүүгийн тайлангийн нэгтгэлд зөрүүтэй тусах эрсдэлтэй, анхаарал татахуйц байгаа тул дараагийн аудитаар авч үзэн тооллого хийн, тооцоо нийлсэн актыг нэг бүрчлэн тулгах нь зүйтэй гэж үзлээ.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

Орлогын данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын алба 2020 оны төсвийн төсөлд өөрийн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг 120,000.0 мянган төгрөгөөр төлөвлөснөөс тайлант хугацаанд 397,619.9 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн байна.

1.2. Эрсдэл:

Төсвийг зөв төлөвлөөгүй байх, төсвийн орлогыг дутуу төвлөрүүлэх.

1.3. Өгсөн зөвлөмж:

Байгууллагын үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогыг бодитой тооцоо судалгаанд үндэслэн төлөвлөх, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3 дахь заалтыг хэрэгжүүлж ажиллах.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

2. Бараа материалын данстай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын албанаас харьяа шүүхийн тамгын газруудад шилжүүлсэн хөрөнгөөс 12 шүүхийн тамгын газартай тооцоо нийлсэн акт үйлдээгүй байна.

2.2. Эрсдэл:

ТЕЗ-ийн санхүүгийн тайлангийн нэгтгэлд зөрүүтэй тусах.

2.3. Өгсөн зөвлөмж:

Жилийн эцсийн бараа материалын тооллого хийхдээ харьяа байгууллагуудтай тооцоо нийлсэн акт үйлдэж санхүүгийн тайланд тусгах, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2 дахь заалтыг хэрэгжүүлж ажиллах.

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

Тус байгууллага нь хагас жилээр үндсэн хөрөнгийн тооллого хийсэн боловч жилийн эцсийн тооллого хийгээгүй байна.

3.2. Эрсдэл:

Байгууллагын хөрөнгө дутах, санхүүгийн тайланд буруу тусах.

3.3. Өгсөн зөвлөмж:

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 2.1-д заасан "үндсэн хөрөнгө, дуусаагүй хөрөнгө оруулалт ба барилга угсралтын ажил, их засварын зардлын тооллогыг жилд нэг удаа /12 дугаар сарын 01-нээс 31-ний дотор;" гэж заасныг мөрдөж, үндсэн хөрөнгийн тооллого хийх.

3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

4. Бараа материалын данстай холбоотой асуудал

4.1. Илрүүлэлт:

Оны эцэст 15,785.0 мянган төгрөгийн түлш, шатах, тослох материал болон сэлбэг хэрэгслийн материалын худалдан авалт хийж бараа материалын нөөц үүсгэсэн байна.

4.2. Эрсдэл:

Хэрэгцээ шаардлагагүй бараа материалыг ихээр нөөцөлж төсвийн мөнгийг үргүй зарцуулах.

4.3. Өгсөн зөвлөмж:

Хэрэгцээ шаардлагагүй бараа материалын нөөц үүсгэхгүй байх, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 16.4.1 дэх заалтыг хэрэгжүүлж ажиллах.

4.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын албаны 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2021			САГ-2021/4/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын алба		Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын алба 2020 оны төсвийн төсөлд өөрийн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг 120.0 сая төгрөгөөр төлөвлөснөөс тайлант хугацаанд 397.6 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3-д "Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын төсвийн орлого, зарлагын зүй зохистой, үр ашигтай байдал, үр дүнгийн гүйцэтгэлийг хангаж, ...", 31 дүгээр зүйлийн 31.4.2-д "төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогын тооцоо," гэж заасантай нийцэхгүй байна.	-	Зөвлөмж өгөх	Гүйцэтгэх нарийн бичгийн дарга Ахлах нягтлан бодогч	О.Амгалан-баатар Ө.Оюунзул
2	Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын албанаас харьяа шүүхийн тамгын газруудад шилжүүлсэн хөрөнгөөс 12 шүүхийн тамгын газартай тооцоо нийлсэн акт үйлдээгүй нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих," гэж заасныг мөрдөж ажиллаагүй байна.	-	Зөвлөмж өгөх	Гүйцэтгэх нарийн бичгийн дарга Ахлах нягтлан бодогч	О.Амгалан-баатар Ө.Оюунзул
3	Тус байгууллага нь хагас жилээр үндсэн хөрөнгийн тооллого хийсэн боловч жилийн эцсийн тооллого хийгээгүй нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 2.1-д заасан "үндсэн хөрөнгө, дуусаагүй хөрөнгө оруулалт ба барилга угсралтын ажил, их засварын зардлын тооллогыг жилд нэг удаа /12 дугаар сарын 01-нээс 31-ний дотор;" гэж заасныг мөрдөж ажиллаагүй байна.	-	Зөвлөмж өгөх	Гүйцэтгэх нарийн бичгийн дарга Ахлах нягтлан бодогч	О.Амгалан-баатар Ө.Оюунзул
4	Оны эцэст 15,785.0 мянган төгрөгийн түлш, шатах, тослох материал болон сэлбэг хэрэгслийн материалын худалдан авалт хийж бараа материалын нөөц үүсгэсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;" гэж заасантай нийцэхгүй байна.	15,785.0	Зөвлөмж өгөх	Гүйцэтгэх нарийн бичгийн дарга Ахлах нягтлан бодогч	О.Амгалан-баатар Ө.Оюунзул
ДҮН		15,785.0			

ТЭМДЭГЛЭЛ

A series of horizontal dotted lines for writing, consisting of 28 lines.